



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 8789

Арвайхээр

Нэмэлт ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулах тухай

Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2, 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалт болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- Төгрөг суманд баригдаж буй Спорт заалны барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Сод ээл” ХХК-ийн гүйцэтгэж буй ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй ногоон байгууламж, гэрэлтүүлэг, явган хүний зам, бетон суурьтай төмөр хашаа, өндөржилтийн зөрүүний ажил, биеийн тамирын тоног төхөөрөмж зэрэг ажлыг нэмэлт ажил гүйцэтгүүлэх гэрээгээр гүйцэтгүүлсүгэй.
- Нэмэлт гэрээ байгуулж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-д даалгасугай.
- Нэмэлт ажилд шаардагдах 108.405.715 (нэг зуун найман сая дөрвөн зуун таван мянга долоон зуун арван тав) төгрөгийг Сангийн яаманд уламжлан тендерийн үнийн зөрүү зардлаас шийдвэрлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД



011101472

D:My Doc. Zahiramj. Zasag darga